

ТАЛХ ЧИХЭР ХК-ИЙН 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

/нэр/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<p>Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.</p>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэг жилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны зурмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Тийм	ТУЗ-н үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажиллах журмуудыг шинэчилсэн.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Тийм	ЗХНЖ-004 Сонгон шалгаруулалтын журамтай бөгөөд Нэр дэвшүүлэх хорооны баримтлах бодлогын баримт бичиг болон журмыг шинэчилсэн	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Тийм	Хувь эзэмшигчдийн хуралд ТУЗ-н үйл ажиллагааг тайлагнаж, компанийн болон хөрөнгийн биржийн веб сайтad байршуулдаг.	2	100%
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Тийм	ТУЗ-н Аудитын, Цалин урамшуулалын, Нэр дэвшүүлэх гэсэн 3-н хороотой. Тус бүрт бодлогын баримт бичгийг баталж өгсөн шалгууртай бөгөөд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор 60:40%-н харьцаатай ажиллаж байна.	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Тийм	Компанийн засаглалын сургалтанд хамруулан сертификатжуулж, ТУЗ-н үйл ажиллагааны журам, Дэд хороодын бодлогын баримт бичиг, үүрэг хариуцлага, шалгуурыг танилцуулж, тогтмол сургалтанд хамруулдаг.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах	Тийм	ТУЗ-ийн даргын ажиллах журамд зааснаар болон компанийн хууль компанийн дүрэмд зааснаар	2	100%

	асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.		хариуцлага хүлээнэ. ТУЗ-н үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.		
ДҮН					
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Тийм	Одоогоор хараат бус гишүүдийн харьцаа 3/1 байна. Цаашид хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх бодлого барьж байна.	2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Тийм	Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Л.Дамдинсүрэн ажилладаг/бодлогын баримт бичиг болон ажиллах журмыг ишигчилсэн/. Аудитын хорооны дарга нь ТУЗ-н дарга бус, хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан.	2	100%
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Тийм	Цалин урамшуулалын даргаар ТУЗ-н хараат бус гишүүн Х.Гиймаа ажилладаг /бодлогын баримт бичиг болон ажиллах журмыг ишигчилсэн/. ТУЗ-н дарга бус, хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан.	2	100%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Тийм	Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүн Д.Баярсайхан ажилладаг /бодлогын баримт бичиг болон ажиллах журмыг ишигчилсэн/. ТУЗ-н дарга бус, хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан.	2	100%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Тийм	Түр хороо байхгүй. ТУЗ-н дэргэдэх байнгын үйл ажиллагаатай Дэд 3-н хороотой. Мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий 9-гишүүн бүрэлдэхүүнтэй.	2	100%
ДҮН					
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					

12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын эсрэмг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Тийм	Компанийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланг хагас жилээр, бүтэн жилийн тайланг тайлагнаж өөрийн компанийн вейб сайтад, хөрөнгийн биржийн сайтад байршуулдаг. Мөн Бодлого, Зорилт, Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлс нээлттэй ил тод вейб сайтад байршуулдаг.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Тийм	Цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэдэг.	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Тийм	Санхүүгийн эрсдлийг ТЧЖ-042 Эрсдлийг удирдах журмаар зохицуулж, жил бүр эрсдлийг матрицын аргаар үнэлж, эрсдлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж ажилладаг.	2	100%
ДҮН					
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүрэг саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Тийм	Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй хөндлөнгийн аудитын байгууллага болох Си Эс Ай Аудитын байгууллагаар гэрээтэй ажиллалаа. Уг үйл ажиллагаанд Аудитын хороо хяналт тавьж ажилладаг.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Тийм	Хөндлөнгийн аудитортой гэрээгээр ажилладаг бөгөөд хувь эзэмшигчдийн хуралд дүгнэлтээ танилцуулдаг.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Тийм	<ul style="list-style-type: none"> Компанийн хэмжээнд менежментийн тогтолцооны дотоод аудиторын гэрчилгээтэй 25-хүний бүрэлдэхүүнтэй баг ажилладаг. Дотоод аудитыг жилдээ 2 удаа зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөтэй. Хүнсний Аюулгүй байдлын ISO 22000:2018-стандартын хэрэгжилтэнд ОУ-ын TUV AUSTRIA- гадны хөндлөнгийн аудитын 	2	100%

			байгууллагаар жилд тутам магадлан аудит ордог.		
ДҮН					
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Тийм	Компанийн хэмжээнд ГЧЖ-042 Эрсдлийг Удирдах журмаар зохицуулж, Эрсдлийн баг 8- гишүүдтэй. Эрсдлээ үнэлж, эрсдлийн менежментийн төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжүүлдэг. Хараат бус байх зарчмыг сургалтаар олгож хэвшлээ.	2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь зурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн эсгийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагсана.	Тийм	ТУЗ-н дэргэд эрсдлийг удирдлагын багтай. Компанийн хэмжээнд Эрсдлийг удирдах журам, баг бүрэлдэхүүн, бүтэцтэй. Удирдлагын дүн шинжилгээний хуралыг төлөвлөгөөний дагуу явуулж, эрсдлийг залруулах арга хэмжээг хугацаатай үүрэг даалгавар өгч, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгалаа.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн харуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Тийм	<ul style="list-style-type: none"> Компанийн хэмжээнд БОАЖЯ-наас Байгаль орчны нарийвчласан үнэлгээг хийж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. ХАБЭА-н нөхцлийн нарийвчласан үнэлгээ, Гамшгийн эрсдлийн үнэлгээг хийлгүүлж, төлөвлөгөө гарган дүрэм, журмаар зохицуулж ажиллалаа. 	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Тийм	ГЧЖ-010 Дотоод хяналтын журмын дагуу Ерөнхий менежерээр ахлуулсан 14-хүний бүрэлдэхүүнтэй баг комплайнсын хяналтыг үнэлж, залруулах арга хэмжээг мэдэгдэх хуудсаар өгч, үр дүнгийн тайланг Гүйцэтгэх захиралд танилцуулдаг бөгөөд хараат бус байж чаддаг.	2	100%
ДҮН					
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					

22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцээс батална.	Тийм	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-н жилийн төсвийг батлуулдаг.	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Тийм	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг КРІ-системээр үнэлж, урамшуулал байдлаар олгодог. Гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэх журамд шалгуур, хэмжих үзүүлэлтийг тусгасан.	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Тийм	ТУЗ-тай байгуулсан гэрээг дүгнэж, гүйцэтгэлийг үнэлж ажиллалаа.	2	100%
ДҮН					
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Тийм	Харилцагч, ханган нийлүүлэгч байгууллагуудтай харилцах үйл явцыг гэрээгээр зохицуулна. Жил тутам ханган нийлүүлэгчдийг үнэлж, сайжруулалт хийж ажилладаг. 2022 онд нийт-22 ханган нийлүүлэгчдийг үнэлсэн. ТЧЖ-051 журмын хүрээнд Гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажилладаг. Оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн хамтран ажиллахыг зориж байна.	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Тийм	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх асуудалд голчлон анхаардаг. Хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байх бодлогыг баримтлан ажиллалаа.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Тийм	Харилцагч талуудын санал хүсэлт, гомдол, мэдээлэл солилцох зорилгоор цахим болон 93339001-утсаар хүлээн авдаг. Хэрэглэгч болон харилцагч байгууллагуудыг жилдээ 3 удаа хүлээн авч үйл ажиллагааг танилцуулж, мэдээлэл солилцлоо.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод	Тийм	МАЖ-002 Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах шийдвэрлэх журмаар зохицуулна. Сургалт хөгжүүлэлтийн ЗХНЖ-003 журмын хүрээнд Сургалт	2	100%

	журам, ажлын төлөвлөгөөтэй байна.		хөгжүүлэлтийн нэгдсэн хөтөлбөр ийг гаргалаа.		
ДҮН					
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, харцуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Тийм	Компанийн ёс зүйн дүрмийг баталлаа. Компанийн үнэт зүйлс, алсын харааг тушаалаар баталж баримтжуулсан.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Тийм	Босоо удирдлагын тогтолцоотой буюу компанийн бүтэц зохион байгуулалтанд тодорхойлсон. Компанийн ёс зүйн дүрэмд зааж өгсөн	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Тийм	Компанийн эрх бүхий албан тушаалтантай тусгайлсан хөдөлмөрийн гэрээ, нууцын гэрээ байгуулж, албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаар дотоод журманд тусгайлан оруулсанаас гадна Ёс зүйн дүрэмд тусгасан	2	100%
ДҮН					
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хургэнэ.	Тийм	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг компанийн болон хөрөнгийн биржийн вейб сайтад байршуулж мэдээллэдэг.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Тийм	Хөрөнгө оруулагч ялангуяа гадаадын дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх тал дээр онцгой анхаардаг бөгөөд тэдгээртэй харилцах хөтөлбөртэй. Гадаадын 10 гаруй орны хөрөнгө оруулагч нартай харилцаж байна.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, ноцгойгоо бүрдүүлнэ.	Тийм	Компанийн вэйб сайтад Хувьцаа эзэмшигч гэсэн цонхтой бөгөөд мэдээллийг байршуулан санал хүсэлт хүлээн авах утас ажиллуулж, Пүрэв гаригт биечлэн уулзах хуваарь гаргаж өгсөн.	2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Тийм	Хувьцаа эзэмшигчдээс авах саналын холбогдох материалыг урьдчилан бэлдэж, танилцуулан цахимаар болон биеэр өгөх өрөө тасалгаа шаардлагатай бусад зүйлээр хангаж өгдөг.	2	100%

36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Тийм	Тусгайлсан журам ТУЗ-ийн гишүүдэд өгөх сургалтандаа уг сэдвийг оруулж өгч зохих мэдлэгийг өгдөг.	2	100%
ДҮН					
НЭГДСЭН ДҮН					

-oOo-